



3rd Story

Есүс бол Бурханы Хүү

The Boy in the Temple.

Есүс бол Бурханы Хүү

– 3rd Story –

Дэйб

Хааяа~~ намайг таних уу? Санах гээд үз л дээ~~ Миний нэрийг Дэйб гэдэг. Би бол Есүсийн ээж болох Мариаг суулгаад Бетелхем руу яваад ирсэн тэр илжиг байна аа. Ааа~~ үнэхээр хүнд аялал байсан шүү. Гэхдээ одоо яалтай ч билээ. Уг нь миний хийх ёстой ажил юм чинь дээ. Тэр үеэс хойш би Иосеф болон Мариагийн гэрт эд зүйл зөөх ч юм уу эсвэл аялалд явах үед ачаа цүнхийг үүрч өгдөг байлаа. Бүр Есүс намайг унасан юм чинь. Гэхдээ дийлэнхдээ би цовхичин давхидаг байсан. Одоо би чинь 12 настай шүү дээ. Надаас одоо ямар хүч гарах вэ дээ? Ингээд бодсон чинь хэдэн өдрийн өмнө болсон явдал санаанд орчихлоо. Та бүхэн мэдэж байгаачлан жилд гурван удаа Иерусалим руу явж баярт оролцохоор явдаг байлаа. Иосеф Мариа бас бяцхан Есүс тэд бүгд баярт оролцохдоо их дуртай шүү. Идэх зүйл уух зүйл ч хангалттай, удаан уулзаагүй хүмүүстэйгээ уулзаж ярилцаж суухад их сайхан байдаг болхоор тэр байх л даа. Гэхдээ өнгөрсөн баяраар Есүс өмнө нь огт үйлдэж байгаагүй нэг зүйл болсон юм.

Аян замын хүн

зааа... Иосеф чи энд байсан юм уу

Аян замын хүмүүс

Иосеф~~!! Мариа~~!!

Аян замын хүн2

Үүнийг хараач ээ, хүүтэйгээ хамт иржээ. Ямар том болоо вэ?

Дэйб

Байнга хийдэг байсантайгаа адилаар хүмүүс идэж ууж бөөн шуугиан наргиантайгаар харилцан өрнүүлж байлаа. Тэгээд баяр дуусаад Иосеф Мариа нар ачаа юугаа бэлдээд миний нуруунд ачиж аваад гэрийн зүг хөдөллөө.

Иосеф



Бүгд бэлэн болсон биздээ?


Хүмүүс

Тийн тийн...тэгэлгүй яахав.

Дэйб

Бид өдөржин замаа дагаад явж байв. Нар жаргаж бүрий болох үеэр ачаагаа буулгаж хоноглохоор майхнаа засахаар болов. Иосеф Мариа хоёр тэр үед Есүс харагдахгүй байгааг анзаарав. Би ч бас адилхан тэр үед л анзаарсан юм чинь... би ч хамт ирсэн бусад амьтадаасаа бас асуув.





Дэйб	Гэтэл тэд бүгд л бүтэн өдрийн турш хараагүй л гэж байна. Харин Иосеф Мариа хоёр бусад хүмүүсийн дунд байгаа л гэж бодож байсан. Ингээд Есүсийг хайж эхлэв.
Аян замын хүн3	Нээрээ, өнөөдөржингөө хараагүй юм байна шүү.
Мариа	Манай хүүг хараагүй биз?
Аян замын хүн4	Хэн билээ? Иаков уу?
Мариа	Үгүй ээ, Есүс ээ Есүс.
Аян замын хүн4	мм...үгүй, хараагүй л юм байна.
Мариа	Ер нь хааччихваа?
Иосеф,Мариа	Есүс~~Есүс~~ Хаана байна аа?
Дэйб	Та нар Есүсийг хараагүй биз?
Камерон	(тэмээний дүр) Тэгээд ямар төрхтэй юм бэ дээ хө?
Дэйб	мм.. жижигхэн. Ээж шиг ээ хөөрхөн инээмсэглэдэг, аав шиг ээ хүрэн бор үстэй...
Камерон	mmm.... үгүй ээ ер нь ийм хүн хичнээн олон билээ дээ...
(!Дэйб) Хүүрнэгч	Мариа болон Иосеф нь хүмүүс дундаас хаанаас ч Есүсийг хайж олж чадсангүй. хаанаас ч хайгаад олдохгүй болохоор ирсэн замаараа буцаж хамт байсан Иерусалим руу буцаж очив. Бусад хүмүүс бүгд гэрлүүгээ явцгаав. Иерусалим руу буцаж очоод Иосеф Мариа хоёр, тэгээд би ч бас аялдан дагаж бид хамтдаа явж ирсэн бүхий л замаараа нэгд нэгэнгүй хайж эхлэв. Бүхэл бүтэн 3 өдрийн турш хайж явсан ч эцэст нь хамгийн сүүлд хайж очсон газраасаа Есүсийг хайж олов. Есүс сүм дотор байж байсан. Тэндээ хуулийг заадаг багш нартай хамт суугаад асууж хариулсан шигээ байж байсан шүү. Есүсийн үгийг сонссон хүмүүс гайхаж, яаж ийм жаахан хүү хуулийн талаар ийм ихийг бас маш тодорхой ойлгосон байх боломжтой вэ гэж маш ихээр гайхширцгааж байв.
Мариа	Есүс! Ээ бурхан минь гэж... Аавтай чинь хамт чамайг ямар их хайсаныг мэдэж байна уу чи? Хаана байгаа нь ч мэдэгдэхгүй хэл үггүй алга болчихоор чинь бид хаанаас олох вэ чамайг?
Иосеф	Юу хийгээд явсан хүүхэд вэ? Яагаад хэлээгүй юм?
Есүс	Яагаад намайг хайсан юм бэ? Би Өөрийн Аавын гэрт байгааг мэдээгүй юм уу?
Иосеф, Мариа	Айн?
Дэйб	Мариа болон Иосеф нь Есүсийн “Би Өөрийн Эцэгийн гэрт байна” гэж хэлсэн үгийг ойлгож чадахгүй байв. Аав Иосефийн гэр нь Назар хотод байдаг бөгөөд тэр гэр рүү явж байсан гэсэн үг юм.



Мариа

Есүс

Дэйб

Одоо гэрлүүгээ явах цаг боллоо.

За ойлголоо, ээжээ.

Есүс эцэг эхтэйгээ хамт замдаа гарлаа. Тэр гурав гурвуулаа Назар хот руу явав. Би ч бас хамт явалгүй л яахав... Назар хотод Есүс өмнө ч тэр одоо ч тэр эцэг эхтэй дуулгавартай байж, хийх ёстой зүйлээ сайн хийдэг цайлган төлөв даруу хүүхэд байв.

Тэр – та нар юунд Намайг хайсан юм бэ? Эцэгийнхээ гэрт байх ёстойг минь мэдсэнгүй гэж үү? гэв. Лук 2:49